ТӨВ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2022/158/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Зуунмод 2022 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit02@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

**Агуулга**

**Товчилсон үгийн жагсаалт ..... 3**
**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 5**
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5**
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5**
**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 7**
**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7**
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9**
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11**
**3. Аудитын тайлан ..... 11**
**3.1 Ерөнхий зүйл ..... 11**
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 12**
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12**
**3.4 Материаллаг байдал ..... 13**
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 13**
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13**
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 15**
**3.8 Аудитын гол асуудал ..... 15**
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15**
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15**
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15**
**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 16**
**4. Аудитын илрүүлэлт ..... 16**
  **4.1 Төлбөрийн акт ..... 16**
  **4.2 Албан шаардлага ..... 16**
  **4.3 Зөвлөмж ..... 17**
**5. Аудитын илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл ..... 18**

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| БСУГ | Боловсрол Соёл Урлагийн газар |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/141

танай ______________-ны № ______________-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ДАЙРИЙМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 он/ALBAN BICHIG
19020455

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **41,083,218.15** | **48,759,780.23** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **41,083,218.15** | **48,759,780.23** |
| **351** | **Түүхий эд материал** | **134,000.00** | **134,000.00** |
| 35130 | Эм боох материал | 134,000.00 | 134,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **40,949,218.15** | **48,625,780.23** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 96,500.00 | 96,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,332,910.00 | 1,325,910.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 996,000.00 | 996,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 38,523,808.15 | 46,207,370.23 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **684,817,065.82** | **672,675,479.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **684,817,065.82** | **672,675,479.16** |
| **392** | **Биет хөрөнгө** | **665,715,065.82** | **653,573,479.16** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 600,054,479.00 | 600,054,479.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (47,611,151.64) | (72,364,510.44) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 100,043,406.00 | 105,763,466.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (70,048,427.03) | (79,728,369.24) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 92,139,800.44 | 110,309,773.38 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (28,280,189.02) | (35,606,290.16) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,668,663.67 | 2,668,663.67 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (769,806.90) | (872,447.82) |
| 93217 | Номын фонд | 17,518,291.30 | 23,348,714.77 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **19,102,000.00** | **19,102,000.00** |
| 39301 | Програм хангамж | 902,500.00 | 902,500.00 |
| 39302 | Хасагдуулга | (902,500.00) | (902,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19,102,000.00 | 19,102,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **725,900,283.97** | **721,435,259.39** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **725,900,283.97** | **721,435,259.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **725,900,283.97** | **721,435,259.39** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 311,643,563.78 | 311,643,563.78 |
| 51102 | - хувийн | 311,643,563.78 | 311,643,563.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **211,834,946.50** | **207,555,065.85** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 211,834,946.50 | 212,020,090.43 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (4,465,024.58) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 202,421,773.69 | 202,236,629.76 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **725,900,283.97** | **721,435,259.39** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **779,818,421.00** | **793,349,802.93** |

| | | | |
|---|---|---|---|
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **18,481,352.00** | **38,072,606.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **18,481,352.00** | **38,072,606.93** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 18,481,352.00 | 38,072,606.93 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 132,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 18,349,352.00 | 38,072,606.93 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **123,483,969.00** | **102,341,296.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 637,853,100.00 | 652,935,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **42,160,669.00** | **16,144,296.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,272,069.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,888,600.00 | 16,144,296.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **81,323,300.00** | **86,197,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 81,323,300.00 | 86,197,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **805,577,320.57** | **793,651,829.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **805,577,320.57** | **793,651,829.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **678,921,872.64** | **727,122,570.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **480,418,622.84** | **514,333,960.43** |
| 210101 | Үндсэн цалин | 334,879,966.50 | 352,439,038.99 |
| 210102 | Нэмэгдэл | 124,405,972.82 | 99,477,877.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,325,704.00 | 11,640,000.00 |
| 210104 | Урамшуулал | 13,806,979.52 | 50,777,043.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **58,545,288.93** | **66,807,191.89** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,942,810.21 | 47,118,194.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,705,469.05 | 5,248,339.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,457,809.64 | 4,144,911.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 580,879.67 | 934,058.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,858,320.36 | 9,361,687.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **75,556,040.30** | **85,169,788.19** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,027,972.90 | 4,373,898.99 |
| 210302 | Түлш, халаалт | 70,175,167.40 | 77,972,409.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,352,900.00 | 2,823,480.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,350,250.00** | **3,653,146.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 295,200.00 | 618,596.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 650,000.00 | 724,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 905,000.00 | 750,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 165,000.00 | 160,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,335,050.00 | 1,400,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | **908,950.00** | **2,807,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 300,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 808,950.00 | 2,507,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **240,000.00** | **299,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 240,000.00 | 299,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,261,600.00** | **-** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,261,600.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **56,641,120.57** | **53,052,083.51** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,058,405.60 | 1,400,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,753,300.00 | 4,508,300.00 |
| | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 45,829,414.97 | 47,143,783.51 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **126,655,447.93** | **66,529,259.49** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **52,405,900.00** | **37,926,100.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,596,800.00 | 29,129,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 29,723,400.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,165,200.00 | 7,875,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920,500.00 | 920,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **74,249,547.93** | **28,603,159.49** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 74,249,547.93 | 28,603,159.49 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(25,758,899.57)** | **(302,026.58)** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 5,666.85 | 1,475,598.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 2,000,000.00 | 2,687,400.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(2,005,666.85)** | **(4,162,998.00)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(27,764,566.42)** | **(4,465,024.58)** |

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 311,663,563.78 | 202,641,240.69 | 154,049,030.38 | 668,353,834.85 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **311,663,563.78** | **202,641,240.69** | **154,049,030.38** | 668,353,834.85 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | (20,000.00) | | 25,764,554.97 | 25,744,554.97 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **311,643,563.78** | **202,421,773.69** | **211,834,946.50** | **725,900,283.97** |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **311,643,563.78** | **202,421,773.69** | **211,834,946.50** | **725,900,283.97** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | | 185,143.93 | 185,143.93 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **311,643,563.78** | **202,421,773.69** | **212,020,090.43** | 726,085,427.90 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (185,143.93) | - | (185,143.93) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | | (4,465,024.58) | (4,465,024.58) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **311,643,563.78** | **202,236,629.76** | **207,555,065.85** | **721,435,259.39** |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **761,469,069.00** | **755,277,196.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **132,000.00** | **-** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **132,000.00** | **-** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 132,000.00 | **-** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 132,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **761,337,069.00** | **755,277,196.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 637,853,100.00 | 652,935,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **42,160,669.00** | **16,144,296.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,272,069.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,888,600.00 | 16,144,296.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **81,323,300.00** | **86,197,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 81,323,300.00 | 86,197,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **761,469,069.00** | **748,706,046.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **761,469,069.00** | **748,706,046.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **634,813,621.07** | **682,176,786.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **480,418,622.84** | **514,333,960.43** |
| 210101 | Үндсэн цалин | 334,879,966.50 | 352,439,038.99 |
| 210102 | Нэмэгдэл | 124,405,972.82 | 99,477,877.48 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,325,704.00 | 11,640,000.00 |
| 210104 | Урамшуулал | 13,806,979.52 | 50,777,043.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **58,545,288.93** | **66,807,191.89** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,942,810.21 | 47,118,194.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,705,469.05 | 5,248,339.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,457,809.64 | 4,144,911.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 580,879.67 | 934,058.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,858,320.36 | 9,361,687.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **75,556,040.30** | **85,169,788.19** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,027,972.90 | 4,373,898.99 |
| 210302 | Түлш, халаалт | 70,175,167.40 | 77,972,409.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,352,900.00 | 2,823,480.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,761,400.00** | **3,578,596.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 330,000.00 | 618,596.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 650,000.00 | 650,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 800,000.00 | 750,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 485,000.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 165,000.00 | 160,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,331,400.00 | 1,400,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **910,000.00** | **2,800,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 300,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 810,000.00 | 2,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **240,000.00** | **299,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 240,000.00 | 299,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,261,600.00** | **-** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,261,600.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **12,120,669.00** | **8,187,850.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,364,069.00 | 1,400,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,756,600.00 | 6,787,850.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **126,655,447.93** | **66,529,259.49** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **54,276,500.00** | **37,926,100.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 19,467,400.00 | 29,129,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 29,723,400.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,165,200.00 | 7,875,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920,500.00 | 920,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **72,378,947.93** | **28,603,159.49** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 72,378,947.93 | 28,603,159.49 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **6,571,150.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | | **6,571,150.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **6,571,150.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **6,571,150.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 6,571,150.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(6,571,150.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **739,132,900.00** | **739,132,900.00** | **-** | **100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **739,132,900.00** | **739,132,900.00** | **-** | **100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **709,082,500.00** | **680,479,340.51** | **28,603,159.49** | **95.97** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **537,195,200.00** | **514,333,960.43** | **22,861,239.57** | **95.74** |
| 210101 | Үндсэн цалин | 349,711,300.00 | 352,439,038.99 | (2,727,738.99) | 100.78 |
| 210102 | Нэмэгдэл | 134,948,400.00 | 99,477,877.48 | 35,470,522.52 | 73.72 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,236,000.00 | 11,640,000.00 | 4,596,000.00 | 71.69 |
| 210104 | Урамшуулал | 36,299,500.00 | 50,777,043.96 | (14,477,543.96) | **139.88** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **72,521,300.00** | **66,807,191.89** | **5,714,108.11** | **92.12** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,033,600.00 | 47,118,194.93 | 3,915,405.07 | 92.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,371,900.00 | 5,248,339.72 | 123,560.28 | 97.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,297,600.00 | 4,144,911.59 | 152,688.41 | 96.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,074,400.00 | 934,058.03 | 140,341.97 | 86.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,743,800.00 | 9,361,687.62 | 1,382,112.38 | 87.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **85,197,000.00** | **85,169,788.19** | **27,211.81** | **99.97** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,224,100.00 | 4,373,898.99 | (149,798.99) | 103.55 |
| 210302 | Түлш, халаалт | 77,972,400.00 | 77,972,409.20 | (9.20) | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,500.00 | 2,823,480.00 | 177,020.00 | 94.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,395,000.00** | **4,395,000.00** | **-** | **100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 350,000.00 | 350,000.00 | - | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 650,000.00 | 650,000.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 750,000.00 | 750,000.00 | - | 100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 485,000.00 | 485,000.00 | - | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 160,000.00 | 160,000.00 | - | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,800,000.00** | **2,800,000.00** | **-** | **100.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,000.00 | 300,000.00 | **-** | **100.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,500,000.00 | 2,500,000.00 | **-** | **100.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** | **-** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 | **-** | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **300,000.00** | **299,400.00** | **600.00** | **99.80** |
| 210702 | Дотоод албан томилолт | 300,000.00 | 299,400.00 | **600.00** | 99.80 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,674,000.00** | **5,674,000.00** | **-** | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,400,000.00 | 1,400,000.00 | **-** | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,274,000.00 | 4,274,000.00 | **-** | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **30,050,400.00** | **58,653,559.49** | **(28,603,159.49)** | **195.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,050,400.00** | **30,050,400.00** | **-** | 100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,129,900.00 | 29,129,900.00 | **-** | **100.00** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920,500.00 | 920,500.00 | - | 100.00 |
| | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **28,603,159.49** | | |
| | Улсын төсвөөс олгосон санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 28,603,159.49 | | |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **739,132,900.00** | **739,132,900.00** | **-** | 100.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | **652,935,900.00** | **652,935,900.00** | **-** | **100.00** |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 652,935,900.00 | 652,935,900.00 | **-** | **100.00** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **86,197,000.00** | **86,197,000.00** | **-** | **100.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 86,197,000.00 | 86,197,000.00 | **-** | **100.00** |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | **-** | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | **-** | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны Гүйцэтгэл |
|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **16,144,296.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **16,144,296.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **8,268,596.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **268,596.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 268,596.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,875,700.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,875,700.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,875,700.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **16,144,296.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **16,144,296.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,144,296.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 16,111.5 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,083.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 15,873.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 11,904.8 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 238.5 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Бараа материал** | 41,083.2 | 48,759.8 | 7,676.6 |
| **Үндсэн хөрөнгө** | 684,817.1 | 672,675.5 | (12,141.6) |
| **Нийт хөрөнгө** | 725,900.3 | 721,435.3 | (4,465.0) |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 725,900.3 | 721,435.3 | (4,465.0) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 725,900.3 | 721,435.3 | (4,465.0) |

Бараа материал дансны үлдэгдэл 48,759.8 мянган төгрөг болж 7,676.6 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь бараа материалын данс 2 иргэнээс 262.5 мянган төгрөгийн ариутгалын болон дархлаажуулалтын бэлдмэл, маск, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 953.9 мянган төгрөгийн ариутгалын бодис, хичээлийн хэрэглэл, Ай Би Би Ай ХХК-аас 1,657.0 мянган төгрөгийн гал тогооны хэрэглэл, Заамар өгөөмөр хайрхан ХХК-аас 685.0 мянган төгрөгийн шалны хулдаас, антенн, Их ундарга майнинг ХХК-аас 1,900.0 мянган төгрөгийн цэцгийн тавиур, шалны хулдаас, теннисний тор, Монгол майнинг ХХК-аас 348.0 мянган төгрөгийн сандал, нийт Нью хайпи ХХК-аас 2,000.0 мянган төгрөгийн сурагчийн

дүрэмт хувцас, Заамар сумын Засаг даргын Тамгын газраас 359.5 мянган төгрөгийн гар ариутгагч бодис, маск, нийт 8,165.9 мянган төгрөгийн хандиваар ирсэн хөрөнгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 672,675.5 мянган төгрөг болж, 12,141.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн дансанд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 6,546.6 мянган төгрөгийн ширээ сандал, ном, Ай Би Би Ай ХХК-аас 2,343.0 мянган төгрөгийн гал тогооны тавилга, тоног төхөөрөмж, Заамар өгөөмөр хайрхан ХХК-аас 3,315.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Их ундарга майнинг ХХК-аас 7,750.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Монгол майнинг ХХК-аас 9,952.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 29,906.6 мянган төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар авснаас нэмэгджээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 793,349.8 мянган төгрөг болж өмнөх оноос 13,531.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 38,072.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 793,651.8 мянган төгрөг болж өмнөх оноос 11,925.5 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 750,302.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 750,302.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 11,169.1 мянган төгрөгөөр бууруулж, 739,132.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 32 арга хэмжээг санхүүжүүлэхээр 739,132.9 мянган төгрөгийн төсөв батлалснаас 652,935.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 86,197.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 652,935.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 86,197.0 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 739,132.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 710,529.7 мянган төгрөгийг зарцуулж, 28,603.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 16,144.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал зардалд 16,144.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар  нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд Боловсрол шинжлэх ухааны яамнаас 6,546.6 мянган төгрөгийн ширээ сандал, ном, Ай Би Би Ай ХХК-аас 2,343.0 мянган төгрөгийн гал тогооны тавилга, тоног төхөөрөмж, Заамар өгөөмөр хайрхан ХХК-аас 3,315.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Их ундарга майнинг ХХК-аас 7,750.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Монгол майнинг ХХК-аас 9,952.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 29,906.6 мянган төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар авснаас нэмэгджээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь 2021 онд нийт 1,032,279.7 мянган төгрөгийн 75 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 674,791.3 мянган төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, хөрөнгө бэлтгээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, цалин хөлстэй холбоотой 1 зөвлөмж, И баримттай холбоотой 1 зөвлөмж,  нийт 3 зөвлөмжийг 100.0 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - | - | - |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 3 | 2,160.7 | 3 | 2,160.7 | - | - | - |
| **Нийт дүн** | **3** | **2,160.7** | **3** | **2,160.7** | **-** | **-** | **-** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 683,211.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 513.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,907.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 674,791.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### 4.1 Төлбөрийн акт

Хөдөлмөрийн чадвар алдсаны актын хугацаа нь 2019 онд дууссан 1 ажилтны цалингаас НДШ-ийг хөдөлмөр чадвар алдалтын хувиар тооцон НДШ-д 466.6 мянган төгрөгийг дутуу, ХХОАТ-т 46.6 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2,4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгал төлнө ,,, ”, 4 дүгээр зүйлийн 4.2-т “Өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн”, санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “*Төлбөрийн акт тогтоохоод дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”,* 4.2.3.3-д “*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”* заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

### 4.2 Албан шаардлага

Байгууллага нь нийт 1 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой 7,907.0 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "*албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*", 4.2.1.8-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

**4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Үндсэн хөрөнгийн дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй, 55 ширхэг 55,353.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

***2. Шилэн данстай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Төв аймгийн Заамар сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль нь 2021 онд нийт 1,032,279.7 мянган төгрөгийн 75 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 674,791.3 мянган төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. *<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал: | | | | | | | | | | | |
| 1 | Цалинг буруу тооцоолж олгосон | 1 | 513.3 | | | 1 | 513.3 | | | | |
| 2 | Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй | 1 | 7,907.0 | | | | | 1 | 7,907.0 | | |
| 3 | Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна | 1 | - | | | | | | | 1 | - |
| **Дүн** | | **3** | **8,420.3** | **-** | **-** | **1** | **513.3** | **1** | **7,907.0** | **1** | **-** |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал: | | | | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй | 1 | 674,791.3 | | | | | | | 1 | 674,791.3 |
| **Дүн** | | **1** | **674,791.3** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **674,791.3** |
| **Нийт дүн** | | **4** | **683,211.6** | **--** | | **1** | **513.3** | **1** | **7,907.0** | **2** | **674,791.3** |